

International Theatre Institute ITI

World Organization for the Performing Arts



2020 Дэлхийн театрын өдрийн мэндчилгээ

Шахид НАДЕЕМ

2020 оны Гуравдугаар сарын 27-ны өдөр

Монгол орчуулга – **Хураангуй хувилбар**

Шахид НАДЕЕМ, Жүжгийн зохиолч, Пакистан улс

Театр – Ариун сүм лугаа адил

Ажока театрын¹ яруу найрагч Булле Шахын² тухай жүжгийн дараа нэгэн настан жаахан хүүгээ дагуулсаар Суфийн³ дүрд тоглосон жүжигчин рүү дөхөн ирэв. Тэр настан “Ач хүү маань өвчтэй. Та түүнийг адислаж үлээж өгөөч” гэв. Жүжигчин гайхан цочирдож “Би Булле Шах бишээ, түүний дүрд тоглосон жижигчин” гэхэд настан “Хүү минь, чи бол жүжигчин биш, чи бол Булле Шахын хойд дүр, түүний *Аватар*⁴!” хэмээсэн юм. Гэнэт жүжиглэх урлаг болон театрын талаар цоо шинэ ойлголт бидэнд төрж, жүжигчин хүн өөрийн бүтээж буй дүрийнхээ хойд дүр нь байж болохыг бид ухаарсан.

Соёл болгонд Булле Шах шиг хүмүүс байдаг ба түүнтэй адил хүмүүсийн түүхийг судалсанаар бид театрын уран бүтээлчид болон театрт хайртай танил биш үзэгчдийн хооронд гүүр болж болно. бид заримдаа тайзан дээр байхдаа театрын талаарх үзэлдээ хэт хөтлөгдөн, нийгмийн оюун санааны сэргээгч байх үүргээ биелүүлж байна гэж бодохдоо нийгмийн асар том хэсгийг анзааралгүй орхигдуулчихсан байдаг. Бид өөрсдөө театрын бидэнд өгдөг оюун санааны гүн уурхайд нэвтрэх боломжоо өнөө тулгарсан сорилтуудыг давар гэсээр алдаж үгүйсгэж байдаг. Өнөөдөр дэлхий дээр муйхарлал, үзэн ядалт болон хүчирхийлэл эрчээ аван даамжирч байна, бидний амьдран буй дэлхий улам бүр доройтож байгаа энэ үед бид оюун санааны хүчээ сэргээх хэрэгтэй.

Бид үлбэгэр дорой, хөшүүн хойрго, гутранги байдалтайгаа, шуналт сэтгэлтэйгээ, амьдарч буй дэлхийгээ үл хүндлэх өөдгүй зан байдалтайгаа бид тэмцэх хэрэгтэй. Театрт үүрэг гэж бий, эрхэм дээд үүрэг бий, тэр нь хүн төрөлхтнийг тамын ёроолд унасан мэт арчаагүй байдлаас нь татан гарган өөд нь өргөхийн тулд эрч хүчээр сэлбэн хөдөлгөх юм.

Зүүн азид байдаг тайз руу гарахын өмнө шаланд нь хүрч адис авдаг уламжлал бол оюун санаа, соёл салшгүй холбоотойг илтгэх маш эртний уламжлал. Уран бүтээлч болон үзэгчид, өнгөрсөн ба ирээдүйн тэр холбоог илтгэх билгэдлийн утгыг сэргээх цаг нь болсон. Театрын бүтээл туурвих нь ариун гэгээн үйл хэрэг байж болно, жүжигчид бодитоор тухайн бүтээж буй дүрийнхээ хойд дүр нь ч болж болно. Ариун сүм болох оюун санааны хязгааргүй орон зай болох боломж театрт л бий.

* Энэхүү мэндчилгээ нь Дэлхийн Театрын Өдөр 2020-д зориулсан мэндчилгээний хураангуй хувилба ба дэлгэрэнгүй хувилбарыг www.world-theatre-day.org сайтаас англи8 франц болон бусад хэлээр үзэж болно.

¹ *Ажока театр*: 1984 онд байгуулагдсан. Ажока гэдэг нь пенжаб хэлээр “орчин үеийн” гэсэн утгатай. Урын санд нь шашны эв нэгдэл, энх тайван, жэндэрийн хамааралтай хүчирхийлэл, хүний эрхийн тухай сэдвүүд голчилсон жүжгүүд бий.

² *Булле Шах (1680-1757)*: Нөлөө бүхий пенжаб суфи найрагч. Энгийн хэлээр гүн ухааны нарийн төвөгтэй асуудлуудаар бичдэг байсан ба шашны ягшмал сургаал болон ноёлогч ангийг хүчтэй шүүмжлэгч байв. Хотоосоо хөөгдөж, буруу номын багш хэмээн ялагдан, нас барсныхаа дараа хотод нь оршуулахаас татгалзсан байдаг. Шашны бүхий л бүлгүүд түүнийг хүндэлдэг.

³ *Суфизм*: лалын шашны шидийн үзэл ба энэ нь хүний сүнсийг тэнгэртэй шууд холбосноор хайрын дээдийг эрэлхийлэх уламжлал.

⁴ *Аватар*: Хиндийн соёлд гэгээрсэн багшийн дэлхий дээр дахин төрсөн хойд дүрийг ингэж нэрлэдэг.